

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2019 оны 07 сарын 04

Тендер шалгаруулалтын нэр: “Дугуй (БелАЗ 7540, HOWO 5707, HOWO 3257, SL-50W № 1,2,3)” нийлүүлэх

Тендер шалгаруулалтын дугаар: МРЦМ/201901369

“Монголросцветмет” ТӨҮГ нь эрх бүхий тендерт оролцогчдоос “Дугуй (БелАЗ 7540, HOWO 5707, HOWO 3257, SL-50W № 1,2,3)” нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Уг тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ:

Багц II: “Монголросцветмет” ТӨҮГ -т HOWO-5707 автомашины 14.00R25 хэмжээтэй дугуй нийлүүлэх

Багц III: “Монголросцветмет” ТӨҮГ -т HOWO-3257,3317 автомашины 12.00R20 хэмжээтэй дугуй нийлүүлэх.

Энэхүү барааны тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэгүй авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50,000.00 /тавин мянган/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс хойш 45 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Борлуулалтын хэмжээ: *2017, 2018 оны аль нэгд гүйцэтгэсэн борлуулалтын хэмжээ тендерт ирүүлсэн үнийн саналын мөнгөн дүнгийн 100%-иас багагүй байна.*

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: *Тендерт санал болгосон үнийн дүнгийн 50 хувиас багагүй байна.*

Туршлага: *Тендерт санал болгож буй үнийн дүнгийн 100%-иас багагүй хэмжээний ижил төстэй бараа, ажил, үйлчилгээг сүүлийн 2 жилд дор хаяж нэг удаа гүйцэтгэсэн байна.*

Тусгай зөвшөөрөл шаардлагатай эсэх: **Шаардлагагүй.**

Тендерийн хамт II багцад 12,712,000 төгрөгийн,

III багцад 4,504,000 төгрөгийн тендерийн баталгааг ирүүлнэ.

Тендерийг *2019 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн 10:00 цагаас* өмнө www.tender.gov.mn хаягаар ирүүлэх ба *мөн өдрийн 10:05 цагт* цахим системээр нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй, эрхгүй эсэх: **Зөвшөөрнө.**

Дотоодын давуу эрх тооцох эсэх. **Тооцохгүй.**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно:

Улаанбаатар хот, БЗД 22-р хороо, Энхтайваны өргөн чөлөө – 98, 405 тоот өрөө, утас: 450060 + 118

“МОНГОЛРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ